



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар A/144

Улаанбаатар хот

Г
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/95 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэгдсэнтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөний 2.5-д батлагдсан Химиийн бодис ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбогдуулан байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх, 3.1.5-д батлагдсан даатгалын үйлчилгээг тус тус шууд худалдан авалтаар, уг төлөвлөгөөний 2.4-т батлагдсан компьютер, принтер болон бусад техник хэрэгсэл худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар гэж өөрчилсүгэй.

2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, Үндэсний геологийн албаны дарга О.Чулуун нарт даалгасугай.

3. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Одхүү/-т үүрэг болгосугай.

